

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нь: *Хууль эрх зүйн тогтолцоо*

Санхүүгийн мэдээллийн албаны дарга Б.Төмөрбат

2011 оны 12 дугаар сарын 21

Сэдэв

1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын эрх зүйн тогтолцоо
 1. Олон улсын конвенцүүд, зөвлөмжүүд
 2. Монгол Улсын хуулиуд
 3. Журмууд
2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэж юу болох тухай
3. Сэжигтэй гүйлгээг мэдээлэх шаардлага, жишээнүүд

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол улсын эрх зүйн тогтолцоо

НҮБ-ын конвенц болон Монгол Улсын нэгдэн орсон бусад гэрээнүүд: 1. Хар тамхи, мансууруулах бодисыг худалдаахын эсрэг /Вена 1988/, 2. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг /Палермо 2001/, Авлигын эсрэг /Мерида 2003/, Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /Нью Йорк 1999/, НҮБ-ын АЗ тогтоол

Монгол Улсын хууль: Эрүүгийн хууль 166-дах хэсэг /2009 он/, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль /2006 он/

Тогтоол, журам: Сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх тухай банкны журам /2007 он/, Харилцагчийг таньж мэдэх банкны журам /2007/, Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам /СЗХ-ны 2009 он/, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам /2009/

НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж олон улсын төвшинд мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр тавигдаж буй шаардлагууд :

- ▶ FATF (Financial Action Task Force буюу Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын түр хороо) 40+9 зөвлөмж
 - ▶ Базелийн хяналт шалгалтын хорооны зөвлөмж (Төв банкуудын хяналт шалгалтын хороо)
 - ▶ Уолсбэрг бүлгийн зөвлөмж (12 банкны бүлэг)
 - ▶ Бүс нутгийн мөнгө угаахтай тэмцэх бүлгүүдийн шаардлага, зөвлөмжүүд (Asia pacific group on money laundering)
 - ▶ Олон улсын байгууллагууд (ДБ, ОУВС, АХБ гэх мэт)
- 

ФАТФ –ын 40 ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж 1. Мөнгө угаах зөрчлийг гэмт хэрэгт тооцох /НҮБ-ын конвенцийн дагуу/

Зөвлөмж 2. Гэмт буруугийн хэлбэрийг бодит баримттай нөхцөл байдалд үндэслэн тогтоох, Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага тооцох

Зөвлөмж 3. Хөрөнгө битүүмжлэх, хураах /ex parte freeze/

Зөвлөмж 4. Санхүүгийн байгууллагын нууцын хууль нь ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд саад болохгүй байх

FATF –ын 40 зөвлөмж /үргэлжлэл/

Зөвлөмж 5. Санхүүгийн байгууллага нь нууц, дугаарласан, эсхүл хуурамч нэр дээр данс нээхийг хориглох. Ингэхдээ харилцагчаа таньж мэдэх /эцсийн үр шимийг хүртэгч хувь хүнийг таних/

Зөвлөмж 6. Улс төрийн албан тушаалтны гүйлгээнд онцгой анхаарал хандуулах

Зөвлөмж 8. Шинэ технологиор үйлчлүүлэгчид онцгой анхаарал хандуулах

Зөвлөмж 10. Гүйлгээ бүрийн мэдээлэл, баримтыг 5-аас доошгүй жил хуулийн байгууллагад өгөх боломжтой байдлаар хадгалах

Зөвлөмж 13. Сэжигтэй гүйлгээг мэдээлэх (Suspicious Transaction Reporting – STR)

FATF –ын тусгай 9 зөвлөмж /үргэлжлэл/

Тусгай зөвлөмж I. Улс орон бүр НҮБ-ын терроризмын эсрэг конвенц, ялангуяа тогтоолуудыг /1267, 1373/ хэрэгжүүлэх шаардлагатай

Тусгай зөвлөмж II. Терроризмыг санхүүжүүлэхийг гэмт хэрэгт тооцох

Тусгай зөвлөмж III. Террористуудын хөрөнгийг битүүмжлэх, хураах (хоцролтгүй)

Тусгай зөвлөмж IV. Терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой сэжигтэй гүйлгээг мэдээлэх

Тусгай зөвлөмж V. Олон улсын хамтын ажиллагаа

Тусгай зөвлөмж VI. Мөнгөн гуйвуулга хийдэг этгээдүүдийг лицензжүүлэх

Тусгай зөвлөмж VII. Цахим шилжүүлэгч бүрийн мэдээллийг авч хадгалах

Тусгай зөвлөмж VIII. Төрийн бус байгууллагад хяналт тавих, бүртгэх

Тусгай зөвлөмж IX. Хилээр бэлэн мөнгө тээвэрлэхэд хяналт тавих



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхийн ач холбогдол, тэмцээгүйн үр дагавар

► УЛС ОРНЫ ТҮВШИНД

- ФАТФ-ын “хамтран ажилладаггүй улс орнуудын жагсаалт”-ад орно, дэлхий нийтэд мэдээлэгдсэнээр тухайн улсын гадаад санхүүгийн харилцаа доголдоно:
 - 2011 оны байдлаар Хойд Солонгос, Иран, Шри Ланка, Боливи, Куба, Этиоп, Кени, Бирм, Сири, Турк гэх мэт 12 улс /хар жагсаалтанд
 - Нэмээд 23 орон /Монголыг оролцуулаад/ хяналтад байгаа /саарал жагсаалтанд/
- Орлогын төлөө гэмт хэргийг нэмэгдүүлнэ
 - Нийгэм, эдийн засгийн аюулгүй байдал, дархлаа алдагдана

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхийн ач холбогдол, тэмцээгүйн үр дагавар

▶ БАЙГУУЛЛАГЫН ТҮВШИНД

- ▶ Нэр хүндийн эрсдэл
 - ▶ Мөнгө угаах гэмт хэргээр хууль хяналтын байгууллагад шалгагдах тухай мэдээлэл харилцагчдад эмзэг тусна
- ▶ Хөрөнгийн эрсдэл
 - ▶ Хууль бусаар олсон хөрөнгө орлого тогтвортой бизнесийг дэмжих найдвартай эх үүсвэр болох нь ховор
- ▶ Хуулийн эрсдэл
 - ▶ Хуулийн байгууллагатай холбогдохтой холбоотой зардал өснө, хуулийн байгууллагын тогтмол хяналтад байна, торгуулах, дампуурах, татан буух

Мөнгө угаах гэж юу вэ?

- НҮБ-ын конвенцид мөнгө угаахыг дараах байдлаар тодорхойлжээ:
 - Тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл үндсэн гэмт хэргийг үйлдэхэд оролцсон этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх;
 - Гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг авах, эзэмших буюу ашиглах;
 - Гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж тухайн эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах;

Мөнгө угаах гэж юу вэ?

- НҮБ-ын конвенцид мөнгө угаах гэмт хэргээр шийтгэхэд дараах зарчмыг баримтлана:
 - Тухайн улс үндсэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд мөнгө угаах гэмт хэргийг хамааруулахгүй байж болно;
 - Мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдэхүүн хэсэг болох ухамсар, санаа, зорилгыг хэргийн бодит нөхцөл байдлыг /objective factual circumstances/ харгалзан тогтоож болно



Мөнгө угаах гэж юу вэ?

- Монгол улсын Эрүүгийн хуулинд /2009 оны 12 дугаар сард орсон нэмэлт өөрчлөлт/
 - “166¹ дүгээр зүйл. Мөнгө угаах. Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор энэ хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн, хувиргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ?

- ▶ НҮБ-ын конвенци:
 - террорист үйл ажиллагаанд ашиглагдахыг мэдсээр байж эсхүл террорист үйл ажиллагаанд ашиглах санаатайгаар шууд болон шууд бусаар, хууль бусаар болон сэтгэлээрээ эд хөрөнгийг цуглуулах, эд хөрөнгөөр хангах үйл ажиллагааг хэлнэ

Терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ?

- ▶ Монгол Улсын Эрүүгийн хууль:
 - 178². Террорист байгууллага болон террорист ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



Сэжигтэй гүйлгээ гэж юу болох тухай

- МУТСТ хуулийн 3.1.5 дахь хэсэгт "сэжигтэй гүйлгээ" гэж:
 - мөнгөний гарал үүсэл тодорхойгүй гүйлгээ,
 - эцсийн хүлээн авагч нь тодорхойгүй гүйлгээ,
 - мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн гүйлгээ,
 - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзэж байгаа гүйлгээг



Сэжигтэй гүйлгээг мэдээлэх

► СМА–наас 2008 онд банкуудад түгээсэн 78 жишээ:

- 1. Харилцагч банкинд байгаа харилцагчийн мэдээлэл, өмнө хийж байсан гүйлгээтэй нь үл нийцэх гүйлгээ, төлбөр тооцоо хийх (Хувь хүн бол нас, ажил мэргэжил, гэрийн хаяг, ерөнхий төрх, гадаад байдал, өмнө хийж байсан гүйлгээг шинжлэх; Компани бол бизнесийн төрөл, үйл ажиллагааны чиглэл, өмнө хийж байсан гүйлгээг шинжлэх);
- 2. Харилцагчийн өмнө хийж заншсан гүйлгээний давтамж, төрөл, хэмжээ тодорхойгүй шалтгаанаар огцом өөрчлөгдөх;
- 3. Харилцагч хууль, журамд заасан, гүйлгээтэй холбоотой мэдээлэл өгөхөөс татгалзах, баримтад илт хуурамч эсхүл тодорхойгүй мэдээлэл бичих;
-
- гэх мэт 78 хүртэл

Сэжигтэй гүйлгээг мэдээлэх

- ФАТФ-ын 14-р зөвлөмж. Санхүүгийн байгууллага, удирдлага, ажилтнууд болон бусад албан хаагчид:
 - а) эрүүгийн ямар гэмт хэрэгт холбоотой болохыг тодорхой мэдэхгүй байсан ч, үнэхээр ийм хууль бус үйлдэл болсон эсэхээс үл хамааран сэжигтэй үйлдлийн талаар СМА-нд шударгаар мэдээлсэн бол гэрээ, хууль, эрх зүйн болон захиргааны актаар тогтоосон мэдээлэл задруулахыг хориглосон заалтыг зөрчсөн гэж эрүүгийн болон иргэний хариуцлагад татахаас хуулиар хамгаалагдсан байх ёстой.
 - б) СМА-нд сэжигтэй гүйлгээний тайлан (СГТ) буюу бусад холбоотой мэдээлэл мэдээлэгдсэн талаар бусдад задруулахыг хуулиар хориглоно.

Сэжигтэй гүйлгээг мэдээлэх

- МУТСТухай хуулийн 12 дугаар зүйл.
Хариуцлагаас чөлөөлөх
 - 12.1.Энэ хуулийн 4.1–д заасан этгээд Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл өгснийг банкны болон мэргэжлийн нууц задруулсан гэж үзэхгүй.
 - 12.2.Энэ хуулийн 4.1–д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсан нь тогтоогдсон ч тухайн мэдээлэл өгсөн этгээдийг захиргааны болон эрүүгийн хариуцлагад татахыг хориглоно.

Сэжигтэй гүйлгээг мэдээлэх

- ▶ 13 дугаар зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах
 - 13.1. Энэ хуулийн 4.1 –д заасан этгээд болон Санхүүгийн мэдээллийн алба нь энэ хуулийн 7.4–т зааснаас бусад этгээдэд харилцагчийн гүйлгээний тухай мэдээлэл өгөх, дамжуулахыг хориглоно.
 - 13.2. Санхүүгийн мэдээллийн албаны дарга, хянан шалгагч албан үүргийнхээ дагуу олж авсан харилцагчийн гүйлгээтэй холбогдсон мэдээллийн нууцлалыг бүрэн эрхийн хугацаанд болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш задруулахыг хориглоно.

Сэжигтэй гүйлгээг мэдээлэх

- ▶ СМА нь хүлээн авсан сэжигтэй гүйлгээний талаар дэлгэрэнгүй судалгаа, шинжилгээ хийх бүх арга хэмжээг авдаг бөгөөд сэжигтэй үйлдлийн талаар хангалттай мэдээлэл байна гэж үзсэн тохиолдолд бусад хуулийн байгуулагад шилжүүлэн шалгуулдаг болно



Сэжигтэй гүйлгээний жишээ 1.

- ▶ Оршин суугч бус харилцагч нарын данс, гүйлгээ /офшор төвүүдэд байршилтай компаниуд/
 - Хөрөнгө нь дансанд уддаггүй
 - Гаднаас шилжүүлгээр орж ирсэн мөнгө богино хугацаанд /өдөртөө юмуу цөөн хэдэн хоногийн дараа/ орж ирсэн юмуу ижил дүнгээр буцаад гардаг
 - Гаднаас орж ирсэн мөнгө тухайн компани, хувь хүний нэр бүхий дансанд удалгүй өөр хүний нэр дээр гадагшилж байдаг гэх мэт

Сэжигтэй гүйлгээний жишээ 2.

- ▶ Гадаадын нэг орноос авилга, хээл хахуулиар олсон мөнгө /3 сая доллар/ Монголд орж ирсэн
 - Монгол хүний нэр дээр компани байгуулсан
 - Компани байгуулсан өдөртөө данс нээнэ
 - 1–3 сарын хугацаанд их хэмжээний мөнгө бага багаар орно
 - Хувааж оруулсан мөнгөө бөөнөөр нь бэлнээр авна, эсхүл өөр хүний данс руу шилжүүлнэ /орон сууцны гэрээ/. Энэ үйл явц давтагдана.
 - Тодорхой хугацааны дараа /1–2 жилийн дараа/ энэ үйл ажиллагаа зогсоно. Данс огт үлдэгдэлгүй юмуу бараг үлдэгдэлгүй үлдэнэ

Сэжигтэй гүйлгээний жишээ 3.

- ▶ Монголын төрийн өмчийн компани, төрийн албан хаагч, албан тушаалтнуудын залилан, луйврын хэрэг:
 - Гадаадын хуурамч компанийн дансанд хуурамч гэрээ ашиглан ихээхэн хэмжээний мөнгө шилжүүлсэн
 - Энэ үйл ажиллагаа олон удаа давтагдана
 - Тухайн улс руу мөнгө шилжүүлсэн өдрийн дараахан биеэр нисч очин бэлнээр аваад Монголд буцаад орж ирдэг

Холбоос

- ▶ www.mongolbank.mn
- ▶ FATF www.fatf-gafi.org
- ▶ APG www.apgml.org
- ▶ UNODC www.unodc.org
- ▶ Basel Committee on Banking Supervision (BCBS) www.bis.org/bcbs/index.htm
- ▶ (Wolfsberg Group, September 2003) www.wolfsberg-principles.com/monitoring.html